

Сангийн сайдын 2013 оны 05
дугаар сарын 31-ний өдрийн 125
дугаар тушаалын 1 дүгээр
хавсралт

Хэнтий аймаг Биндэр сум

ҮНИЙН САНАЛ АВАХ ЖИШИГ БАРИМТ БИЧИГ

**(ХАРЬЦУУЛАЛТЫН АРГААР БАРАА
ХУДАЛДАН АВАХАД АШИГЛАНА)**

2024 оны 02 дугаар сарын 14

Хэнтий аймаг Биндэр СЭМТ

ОРШИЛ

“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хууль, тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Сангийн яамнаас боловсруулсан энэхүү үнийн санал авах жишиг баримт бичгийг Захиалагч байгууллага 50,000,000 төгрөгөөс доош төсөвт өртөгтэй бараа нийлүүлэх гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар сонгох болон шууд гэрээ байгуулах үед мөрдөнө.

Үнийн санал авах жишиг бичиг баримтын заалтуудад зарчмын бус өөрчлөлт оруулж тухайн барааг худалдан авах ажиллагаанд тавигдах шаардлагад нийцүүлбэл зохино. Эдгээр өөрчлөлтийг хийхдээ дараах удирдамжийг дагаж мөрдөнө

1. Үнийн санал авах баримт бичгийг худалдан авах бараа буюу төслийн онцлог байдалд нийцүүлэн энэхүү жишиг баримт бичгийн дагуу бэлтгэнэ.
2. Захиалагч налуу үсгээр хаалтанд бичсэн жишээ, зааврын оронд тохирох үг өгүүлбэр, тоо хэмжээ, хувь, валют зэргийг бөглөнө. Үнийн санал ирүүлэгчийн бөглөх хэсгийг захиалагч бөглөхгүй орхино.
3. Үнийн санал авах жишиг баримт бичгийн зүүлт/тайлбар болон санамж нь захиалагчид заавар өгөх зорилготой тул үнийн санал авах баримт бичгийг бэлтгэхдээ тэдгээрийг хасна.

Энэхүү тендерийн баримт бичигтэй холбоотой асуулт ирүүлэх, тайлбар эсвэл нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар холбоо барина уу.

Сангийн яамны Хууль, худалдан авах ажиллагааны бодлогын газар

Утас: 267416, 267648

Web: www.e-procurement.mn

Хэнтий аймаг Биндэр СЭМТ

Огноо: 2024/02/14

ШАТАХУУН, ШАТАХ ТОСЛОХ МАТЕРИАЛ НИЙЛҮҮЛЭХ
ҮНИЙН САНАЛ
АВАХ БАРИМТ БИЧИГ

Төслийн нэр:

Шатахуун, шатах тослох материал худалдан авах

Төслийн дугаар:

№ ХАБСДЭ/20240102002

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Хэнтий Бүндэр СЭМТ нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос шатхуун, шатах тослох материал нийлүүлэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг **[2024/02/21 10:00]**-аас өмнө **Хэнтий Аймаг Бүндэр СЭМТ 111 тоотод Их эмч О.Даваасоёмбо Утас 98081177 tender.gov.mn** хаягаар ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2024/02/21** ны өдрийн **[10:30]**¹-т нээнэ.

Дотоодны давуу эрх тооцох эсэх.²

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Хэнтий Аймаг Бүндэр СЭМТ 111 тоотод Их эмч О.Даваасоёмбо Утас 98081177

¹ Тендерийг хүлээж авах эцсийн хугацааг дууссанаас хойш 1 цагийн дотор байна.

² Захиалагч тендер шалгаруулалтад давуу эрхийн зөрүү хэрэглэхгүй бол, энэ өгүүлбэрийг хасч оронд нь “Монгол Улсын гарал үүсэлтэй бараанд давуу эрхийн зөрүү тооцохгүй” гэж бичнэ.

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа**

1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**

2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.

2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.

2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**

3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:

 - (а) Үнийн санал;
 - (б) Үнийн боло нийлүүлэлтийн хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тогтмол үнэ**

4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
- 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**

5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.

5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.


6. **Үнийн саналын хүчинтэй байх хугацаа** 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.
7. **Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх** 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
8. **Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл** 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. **ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<p>Сүүлийн 2022, 2023 оны жилийн санхүүгийн тайлан /шаардлагатай бол аудитын дүгнэлтийн хамт/;</p> <p>Сүүлийн 2 жилийн туршлагын мэдээлэл /гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/;</p> <p>Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай.</p> <p>Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - ААНБ-ын гэрчилгээ - Татварын газарын лавлагаа - Нийгмийн даатгалын лавлагаа.
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Хэнтий Аймаг Биндэр СЭМТ 111 тоотод Их эмч О.Даваасоёмбо Утас 98081177</p> <p>Огноо: 2024 оны 02 дүгээр сарын 21-ны өдөр]</p> <p>Цаг: 10 цаг 00 минут г.м]</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг Хэнтий Аймаг Биндэр СЭМТ 111 тоот</p> <p>Огноо: 2024 оны 02 дүгээр сарын 21 -ны өдөр]</p> <p>Цаг: 10 цаг 30 минут</p>
ТӨӨЗ 2.3	<p>Дөрөвдүгээр бүлгийн маягтуудаас гадна эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох дараах баримт бичиг, материалыг өөрийн тендертээ нууцлахгүй ирүүлнэ. Үүнд:</p> <p>1.</p>
ТӨӨЗ 6.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: Шатахуун, шатах тослох материал худалдан авах, ХАБСДЭ/20240102002</p>

Гурав. **ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

БАТЛАВ:
ЭРХЛЭГЧ ЭМЧ *Ц.Өсөхбаяр* Ц.ӨСӨХБАЯР



БИНДЭР СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
“ШАТАХУУН, ШАТАХ ТОСЛОХ МАТЕРИАЛ”-Н ТЕХНИКИЙН
ТОДОРХОЙЛОЛТ

2024 онд хэргэлэгдэх шатахуун, шатах тослох материал буюу шаталт сайтай, сайн чанарын АИ-92 бинзен сар бүр 1 800 000 төгрөгнд худалдан авах.

№	Сарууд	Зардал
1	1 сар	1 800 000
2	2 сар	1 800 000
3	3 сар	1 800 000
4	4 сар	1 800 000
5	5 сар	1 800 000
6	6 сар	1 800 000
7	7 сар	1 800 000
8	8 сар	1 800 000
9	9 сар	1 800 000
10	10 сар	1 800 000
11	11 сар	1 800 000
12	12 сар	1 800 000
Нийт		21 600 000